



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 1/35

Хэрлэн сум

Төслийн уулзалт, чуулга уулзалтад
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гадаад харилцааны сайдын 2016 оны А/36 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг дарга Батмөнхийн Цогт-Оршихыг Бүгд найрамдах Солонгос улсын Жэжү мужид 2017 оны 3-р сарын 03-наас 09-ний өдрүүдэд зохион байгуулагдах "Гүүд Хийлт Гүүд Ворлд" төслийн уулзалтанд, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Цогтбаатарын Соёл-Эрдэнийг Бүгд найрамдах Солонгос улсад 2017 оны 1 дүгээр улиралд зохион байгуулагдах Ази, Номхон далайн бүсийн бүртгэлийн ажилтны чуулга уулзалтанд тус тус оролцуулсугай.

Хоёр. Дипломат, албан паспорт олгохтой холбоотой асуудлыг Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлэхээр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулгад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 363